

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-4

1.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал	3-4
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 10-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 19 цаг 24 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Номтойбаяр, Л.Гантөмөр, Ц.Туваан;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Ж.Баярмаа, Ц.Сандаг-Очир, Ө.Шижир,
Б.Пүрэвдорж, Л.Оюун-Эрдэнэ, Э.Одбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Доржханд.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлаас Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл 1 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 1 цагийн завсарлага авав./19:30/

Хуралдаан 19 цаг 30 минутаас 20 цаг 40 минутад завсарлав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлаас Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн авсан завсарлагын хугацаа дууссан тухай мэдэгдэж, хуралдааныг Пүрэв гарагийн өглөөний 10.00 цаг хүртэл хойшлуулж байгаа талаар мэдэгдэв./20:40/

Хуралдаан 7 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 20 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 19 цаг 24 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Одоогийн байдлаар Жадамбын Бат-Эрдэнэ, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна.

Ирээгүй гишүүдийг урьж байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирээгүй байна, Батын Батбаатар гишүүнийг урьж байна. Тогмидын Доржханд гишүүнийг урьж байна. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүнийг урьж байна. Цэвэгдоржийн Туваан гишүүнийг урьж байна. Дашцэвэгийн Амарбаясгалан гишүүнийг урьж байна. Жудгийн Баярмаа гишүүнийг урьж байна. Нямтайширын Номтойбаяр гишүүнийг урьж байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнийг урьж байна. Одонгийн Цогтгэрэл гишүүнийг урьж байна. Сайнбуянгийн Амарсайхан гишүүнийг урьж байна. Лувсаннъямын Гантөмөр гишүүнийг урьж байна. Эрдэнэбилигийн Одбаяр гишүүнийг урьж байна. Цэндийн Сандаг-Очир гишүүнийг урьж байна. Өлзийхүүгийн Шижир гишүүнийг урьж байна аа.

Ингээд гишүүд танхимдаа хүрэлцэн ирэхийг хүсэж байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя.

Дашцэвэгийн Амарбаясгалан гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Ням-Осорын Учрал гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн. Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн, Батын Батбаатар гишүүн ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Нэг асуудал байгаа.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал байна.

Ингээд хэлэлцэх асуудалтай дээр саналтай гишүүд байна уу? Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Гишүүдэд оройн мэнд хүргэе.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох асуудал Улсын Их Хурлаар орж ирж байна. Энэ асуудалтай холбогдуулж АН-ын бүлэг хуралдсан. Тэгээд түр хугацаагаар АН-ын бүлэг хойшилсон байгаа. Хойшилсон шалтгаан нь бас энэ Улсын Их Хурал төрийн шийдвэр гаргах үйл явцтай холбоотойгоор баяр ёслолын өдрүүдэд бас шийдвэр гаргах нь өөрөө хуульд нийцэх эсэх зэрэг асуудлууд болоод бусад асуудлаар бид нар бас ярилцаж түр хойшилсон байсан. Ийм учраас бас АН-ын бүлгийн зүгээс нэг цагийн завсарлага авч энэ асуудлыг бид нар эргэж ярилцах ийм шаардлагатай байна. Бас энэ үндэслэлүүд дотор бид нар шинээр томилогдох магадгүй Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн байгаа нэр дэвшигчтэй холбоотой нэр дэвшигчид тодорхой бодлогын асуудлуудаар гэх зэрэг бүлэг дээр ярилцах маш олон асуудлууд бас бий.

Тийм болохоор ТББХ-ны хуралдаанаас нэг цагийн завсарлага АН-ын бүлэгт өгнө үү гэдгийг хүсье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн хуралдаанаас завсарлага авах тухай гээд.

12.1 энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага эрх авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдөр сунгаж болно гэсэн байна.

12.4 дээр шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлаар нам эвслийн бүлэг завсарлага авах бол хуралдаан даргалагч завсарлагын хугацааг тухайн асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх боломжтой байхаар тогтооно гэх зэрэг заасан байгаа.

Ингэж заасан энэ хуулийн дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг нэг цагаар завсарлуулъя аа. Цогтгэрэл гишүүний хүсэлт гаргасан АН-ын бүлгийн хүсэлтийн дагуу нэг цагийн завсарлага өгье.

Завсарлага, нэг цагийн завсарлага 20 цаг 30 минут хүртэл завсарлага.

ЗАВСАРЛАГА

Ж.Бат-Эрдэнэ: АН-аас авсан Төрийн байгуулалтын байнгын хорооноос авсан нэг цагийн завсарлага дууслаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг Пүрэв гаргийн өглөөний 10 цаг хүртэл хойшлууллаа.

20.45 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА